# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр Дугаар А/78 Улаанбаатар хот

"Багахангай фүүд" фестиваль
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих" зорилтот жилийн хүрээнд үндэсний болон олон орны хоолны соёлыг иргэдэд таниулах "Багахангай фүүд" фестиваль арга хэмжээг дүүргийн 2 дугаар хороонд 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсугай.

2.Зохион байгуулах арга хэмжээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зарцуулах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг чанар үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн болон зэргэлдээх сумуудын хоол үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, туршлага солилцох, хамтын ажиллагааг нэмэгдүүлж ажиллахыг Хотын стандарт, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар), 1,2 дугаар хорооны Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 17,890,000 ( арван долоон сая найман зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэд, олон нийтэд сурталчлан ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010265

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 23 -ны өдрийн
А/78 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСЭГ

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Г.Дагвадорж | Дүүргийн менежер |
| Гишүүд: | Б.Отгонжаргал | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Д.Хүрэлбаатар | Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга |
| | Н.Нямзав | 1 дүгээр хорооны Засаг дарга |
| | Б.Батзориг | 2 дугаар хорооны Засаг дарга |
| | Б.Алтанцоож | Соёлын ордны захирал |
| | М.Өсөхдэлгэр | Багахангай Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн захирал |
| | Д.Энхтайван | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга |
| | Х.Ганбат | Эрүүл мэндийн төвийн дарга |
| | Б.Цогбадрах | Онцгой байдлын хэлтсийн дарга |
| | Т.Лхагвасүрэн | Цагдаагийн хэлтсийн дарга |
| | Ч.Батхуяг | Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирал |
| | Б.Гэрэлмаа | Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал |
| | Б.Мөнхтүвшин | Багахангай Хүнсний хувьсал ТББ-ын тэргүүн |
| Нарийн бичиг: хэлтсийн | Ё.Гэрэлцэцэг | Хүнс, худалдаа үйлчилгээний Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл |

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 23 -ны өдрийн
А/78 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“БАГАХАНГАЙ ФҮҮД” ФЕСТИВАЛЬ-Д
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

| № | Бараа материалын нэр | | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Шагнал | | | | | | |
| 1 | Өргөмжлөл | Food фестиваль | ш | 4 | 100,000 | 400,000 |
| 2 | | Бүжгийн тэмцээн | ш | 3 | 100,000 | 300,000 |
| 3 | Food фестиваль | 1-р байр | ш | 1 | 1,000,000 | 1,000,000 |
| 4 | | 2-р байр | ш | 1 | 800,000 | 800,000 |
| 5 | | 3-р байр | ш | 1 | 600,000 | 600,000 |
| 6 | | Тусгай байр | ш | 1 | 300,000 | 300,000 |
| 7 | Бүжгийн тэмцээн | Хосоор 2х3 | ш | 1 | 240,000 | 240,000 |
| 8 | Оролцох багийн хүнсний бүтээгдэхүүн (багц) | | баг | 10 | 150,000 | 1,500,000 |
| 9 | Асар(4х6) | | ш | 2 | 2,200,000 | 4,400,000 |
| 10 | Асар(3х3) | | ш | 3 | 650,000 | 1,950,000 |
| 11 | Урлагын багц | | - | 1 | 5,000,000 | 5,000,000 |
| 12 | Шүүгч | | тоо | 6 | 150,000 | 900,000 |
| 13 | Бэлтгэл ажил (тохижилт г.м бусад) | | - | - | 500,000 | 500,000 |
| Нийт | | | | | | 17,890,000 |